

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/88/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Төлбөрийн акт	16
4.2 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
Л.БАТХУЯГ ТАНАА

№ 2/115

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

Сумын ЗДТГ-ын 2021.12.14-ний өдрийн А/32 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсэг томилогдож эд хөрөнгийг тоолсон ба тооллогын комисс нь тооллого хийсэн тухай тэмдэглэл үйлдэж өмч хамгаалах зөвлөлд хүргүүлээгүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор

d:\alban.bichig.a4-toot.docx

• 005020525

бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана”, гэсэн заалт санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байдал”, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,909,461.66	145,015,582.66
33	АВЛАГА	12,103,500.00	7,040,621.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	420,000.00
335	Бусад авлага	10,100,000.00	2,271,121.00
3351	Байгууллагаас авах авлага	10,100,000.00	2,271,121.00
336	Зээлийн авлага	2,003,500.00	4,349,500.00
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	2,003,500.00	4,349,500.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	2,003,500.00	4,349,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	114,805,961.66	124,974,961.66
351	Түүхий эд материал	46,321,081.66	46,321,081.66
35110	Тусгай зориулалттай материал	46,321,081.66	46,321,081.66
35300	Бэлэн бүтээгдэхүүн	7,408,000.00	16,627,000.00
354	Хангамжийн материал	11,460,880.00	12,410,880.00
35410	Бичиг хэргийн материал	3,248,250.00	3,548,250.00
35420	Аж ахуйн материал	6,068,480.00	6,718,480.00
35470	Бусад хангамжийн материал	2,144,150.00	2,144,150.00
35600	Мал амьтад	49,616,000.00	49,616,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	10,000,000.00	13,000,000.00
36600	Бусад нөөц	10,000,000.00	13,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,172,251,836.58	3,006,766,740.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,172,251,836.58	3,006,766,740.26
392	Биет хөрөнгө	3,034,913,836.58	2,869,578,740.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,633,166,850.00	3,723,066,850.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-919,167,855.20	1,134,204,299.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,232,385.00	217,932,385.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-116,499,674.54	-136,375,815.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	186,182,595.50	207,895,035.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-151,540,662.05	-161,076,658.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,791,544.00	69,611,544.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,173,655.18	-48,507,579.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	240,790,376.13	240,790,376.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-77,001,467.08	-109,686,497.24
39217	Ном	133,400.00	133,400.00
393	Биет бус хөрөнгө	137,338,000.00	137,188,000.00
39301	Програм хангамж	1,150,000.00	1,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	136,738,000.00	136,738,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,309,161,298.24	3,151,782,322.92
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	609,828.00	12,500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	609,828.00	12,500.00
413	Өглөг	609,828.00	12,500.00
4136	Бусад өглөг	609,828.00	12,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	609,828.00	12,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,308,551,470.24	3,151,769,822.92
51	Засгийн газрын хувь оролцоо	3,308,551,470.24	3,151,769,822.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	684,879,255.00	684,879,255.00
51101	Өмч: - төрийн	684,879,255.00	684,879,255.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,074,556,015.15	1,917,774,367.83
1210	Өмнөх үеийн үр дүн	2,074,556,015.15	2,074,556,015.15
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-156,781,647.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	549,116,200.09	549,116,200.09

**Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,309,161,298.24	3,151,782,322.92
----------	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,041,855,299.66	655,362,908.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	604,893,094.66	218,135,230.00
120	Нийтлэг татварын бус орлого	604,893,094.66	218,135,230.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	604,893,094.66	10,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	403,220.00	10,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	604,489,874.66	00.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	101,972,580.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	00.00	116,152,650.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	436,962,205.00	437,227,678.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,730,705.00	16,949,778.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	16,949,778.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	78,730,705.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358,231,500.00	420,277,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,231,500.00	420,277,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	640,324,136.19	698,110,905.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	640,324,136.19	698,110,905.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	622,809,472.70	658,263,658.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,633,512.51	225,677,772.27
210101	Үндсэн цалин	225,633,512.51	223,765,836.57
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,911,935.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,434,871.00	29,533,976.12
210201	Тэтгэврийн даатгал	19,922,507.00	21,097,625.88
210202	Тэтгэмжийн даатгал	1,732,653.00	2,128,341.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,792,811.00	1,702,554.03
210204	Ажилгүйдлийн даатгал	453,300.00	410,099.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,533,600.00	4,195,355.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,777,782.00	16,417,138.00
210301	Гэрэл, цахилгаан	2,081,080.00	2,796,136.00
210302	Түлш, халаалт	13,696,702.00	13,021,002.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,997,326.00	38,242,410.00
210401	Бичиг хэрэг	3,992,900.00	4,719,400.00
210402	Тээвэр, шатахуун	17,943,926.00	21,256,510.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,564,000.00	3,564,000.00
210404	Ном, хэвлэл	1,396,500.00	1,489,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	6,180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	1,033,500.00
2105	Нормативт зардал	110,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	110,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,640,000.00	11,457,500.00
210604	Урсгал засвар	1,640,000.00	11,457,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,730,000.00	4,390,620.00
210702	Дотоод албан томилолт	5,730,000.00	4,390,620.00

**Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	67,010,920.00	14,649,626.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,965,202.00	12,281,213.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	238,050.00	470,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	231,768.00	424,488.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	88,000.00
210807	Газрын төлбөр	275,900.00	885,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	250,475,061.19	317,594,616.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,653,850.00	33,849,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	128,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	234,721,211.19	283,617,536.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,514,663.49	39,847,246.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	24,291,419.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,111,419.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	7,180,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,714,663.49	13,292,185.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,300,000.00	2,263,641.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,300,000.00	2,263,641.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	401,531,163.47	-42,747,997.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	35,669,829.64	114,033,650.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	35,669,829.64	114,033,650.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-35,669,829.64	114,033,650.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	365,861,333.83	156,781,647.32

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	437,365,425.00	434,974,037.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	403,220.00	10,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	403,220.00	10,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	403,220.00	10,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	403,220.00	10,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	436,962,205.00	434,964,037.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,730,705.00	14,686,137.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	14,686,137.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	78,730,705.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	358,231,500.00	420,277,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	358,231,500.00	420,277,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	427,801,425.00	418,814,177.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,801,425.00	418,814,177.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	410,286,761.51	380,336,530.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,633,512.51	229,175,883.47
210101	Үндсэн цалин	225,633,512.51	227,263,947.77
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	1,911,935.70

**Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,434,871.00	26,455,864.92
210201	Тэтгэврийн даатгал	19,922,507.00	18,019,514.68
210202	Тэтгэмжийн даатгал	1,732,653.00	2,128,341.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,792,811.00	1,702,554.03
210204	Ажилгүйдлийн даатгал	453,300.00	410,099.45
210205	Эрүүл мэндийн даатгал	4,533,600.00	4,195,355.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,917,782.00	16,411,138.00
210301	Гэрэл, цахилгаан	2,221,080.00	2,796,136.00
210302	Түлш, халаалт	13,696,702.00	13,015,002.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,923,573.00	38,808,370.00
210401	Бичиг хэрэг	4,556,900.00	4,725,400.00
210402	Тээвэр, шатахуун	20,156,173.00	21,263,970.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,714,000.00	3,564,000.00
210404	Ном, хэвлэл	1,396,500.00	1,789,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	6,180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,100,000.00	1,286,000.00
2105	Нормативт зардал	110,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	110,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	11,842,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	400,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,850,000.00	11,842,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,730,000.00	4,390,620.00
210702	Дотоод албан томилолт	5,730,000.00	4,390,620.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,259,423.00	17,605,474.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,213,705.00	14,627,233.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	238,050.00	470,775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	231,768.00	424,488.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	88,000.00
210807	Газрын төлбөр	275,900.00	1,494,978.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,027,600.00	35,346,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,927,600.00	35,218,680.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	100,000.00	128,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,514,663.49	38,477,646.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	22,921,819.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	17,111,419.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	5,810,400.00
2134	Орон нутгийн төсвийн өрөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,714,663.49	13,292,185.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,714,663.49	13,292,185.81
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,300,000.00	2,263,641.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,300,000.00	2,263,641.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9,564,000.00	16,159,860.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,564,000.00	16,159,860.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,564,000.00	16,159,860.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,564,000.00	16,159,860.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,564,000.00	16,159,860.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-9,564,000.00	-16,159,860.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00

**Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
-----------	--	-------	-------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

мянган төгрөгөөр					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,410,503,861.22	2,943,299,964.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	298,800,648.10	298,800,648.10
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,709,304,509.32	3,242,100,612.51
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	298,800,648.10	00.00	-298,800,648.10
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	365,251,505.83	365,251,505.83
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	2,074,556,015.15	3,308,551,470.24
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	2,074,556,015.15	3,308,551,470.24
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	2,074,556,015.15	3,308,551,470.24
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-156,781,647.32	-156,781,647.32
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	549,116,200.09	1,917,774,367.83	3,151,769,822.92

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	421,277,900.00	406,995,714.19	14,282,185.8	96.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	421,277,900.00	406,995,714.19	14,282,185.8	96.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,205,300.00	384,073,894.39	14,131,405.6	96.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,077,900.00	229,175,883.47	3,902,016.5	98.3
210101	Үндсэн цалин	228,037,900.00	227,263,947.77	773,952.2	99.7
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	1,911,935.70	3,128,064.3	37.9

**Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,465,400.00	26,455,864.92	5,009,535.1	84.1
210201	Тэтгэврийн даатгал	22,142,400.00	18,019,514.68	4,122,885.3	81.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,330,800.00	2,128,341.60	202,458.4	91.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,864,600.00	1,702,554.03	162,046.0	91.3
210204	Ажилгүйдлийн даатгал	466,100.00	410,099.45	56,000.6	88.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,661,500.00	4,195,355.16	466,144.8	90.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,109,600.00	16,411,138.00	1,698,462.0	90.6
210301	Гэрэл, цахилгаан	4,494,500.00	2,796,136.00	1,698,364.0	62.2
210302	Түлш, халаалт	13,015,100.00	13,015,002.00	98.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00	0.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	40,396,000.00	38,808,370.00	1,587,630.0	96.1
210401	Бичиг хэрэг	4,992,000.00	4,725,400.00	266,600.0	94.7
210402	Тээвэр, шатахуун	21,380,000.00	21,263,970.00	116,030.0	99.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,564,000.00	3,564,000.00	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	2,380,000.00	1,789,000.00	591,000.0	75.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,180,000.00	6,180,000.00	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,900,000.00	1,286,000.00	614,000.0	67.7
2105	Нормативт зардал	300,000.00	300,000.00	0.0	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,152,500.00	28,002,360.00	150,140.0	99.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,309,200.00	16,159,860.00	149,340.0	99.1
210604	Урсгал засвар	11,843,300.00	11,842,500.00	800.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	4,942,000.00	4,390,620.00	551,380.0	88.8
210702	Дотоод албан томилолт	4,942,000.00	4,390,620.00	551,380.0	88.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,001,900.00	5,182,978.00	818,922.0	86.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,724,400.00	2,204,737.00	519,663.0	80.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	480,000.00	470,775.00	9,225.0	98.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	661,800.00	424,488.00	237,312.0	64.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	130,000.00	88,000.00	42,000.0	67.7
210807	Газрын төлбөр	1,505,700.00	1,494,978.00	10,722.0	99.3

**Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35760000.00	35346680.00	413,320.0	98.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,600,000.00	35,218,680.00	381,320.0	98.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	160,000.00	128,000.00	32,000.0	80.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23072600.00	22921819.80	150,780.2	99.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,072,600.00	22,921,819.80	150,780.2	99.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,172,600.00	17,111,419.80	61,180.2	99.6
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,900,000.00	5,810,400.00	89,600.0	98.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	421,277,900.00	406,995,714.19	14,282,185.8	96.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	420,277,900.00	406,985,714.19	13,292,185.8	96.8
132001	Орон нутгийн төсвөөс	420,277,900.00	406,985,714.19	13,292,185.8	96.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	10,000.00	990,000.0	1.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	10,000.00	990,000.0	1.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	6	6	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,430,705.00	12,422,496.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,430,705.00	12,422,496.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,430,705.00	12,422,496.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	72430705.00	12,422,496.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	72430705.00	12,422,496.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72430705.00	12422496.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72430705.00	12422496.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,422,496.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72430705.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 01 дүгээр сарын 13 өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Шинэжинст сумын ЗДТГ-ын дарга Л.Батхуяг, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Доржсамбуу нар зурж байна.

3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шинэжинст сумын ЗДТГ нь "Нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн үйл ажиллагааг нь жигдрүүлэх, сумын ЗДТГ болон иргэдийн нийтийн хурлын үндсэн зорилт, чиг үүргийг иргэдэд ойлгуулах, иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллагын хамтын ажиллагаа, иргэдийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, төлөөлөгчдийг чадваржуулах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, ажлын хариуцлагыг өндөржүүлэх, Нутгийн өөрөө удирдах байгууллагыг хөгжүүлэн бэхжүүлэхэд шинэ сэтгэлгээ, шинэлэг арга барилаар ажиллах, хурлаар хэлэлцэх асуудлыг зөв оновчтой тогтоон, байгууллага, иргэдийн саналыг тусгах, сумын өнгө төрх, ард түмнийхээ амьдралын түвшнийг дээшлүүлэхэд боловсролоор дамжуулан ажилгүйдэл, ядуурлыг багасгахад оршино" эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж иржээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 640,933.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,614.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,729.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал 6,729.8 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,151,782.3 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 157,379.0 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	136,909.5	145,015.6	8,106.1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	12,103.5	7,040.6	(5,062.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	124,806.0	137,975.0	13,169.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,172,251.8	3,006,766.7	(165,485.1)
Үндсэн хөрөнгө	4,479,185.2	4,597,317.6	118,132.4
Хуримтлагдсан элэгдэл	(1,306,933.3)	(1,590,550.9)	(283,617.5)
Нийт хөрөнгө	3,309,161.3	3,151,782.3	(157,379.0)
Өр төлбөр	609.8	12.5	(597.3)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,308,551.5	3,151,769.8	(156,781.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,309,161.3	3,151,782.3	(157,379.0)

/Эх сурвалж: Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлангаас/

Авлагын дансны 7,040.6 мянган төгрөг болж 5,062.9 мянган төгрөгөөр өссөн нь дундын сангийн авлага 420.0 мянга, тээвэр шатахууны авлага 7.5 мянга, татаас санхүүжилтийн авлага 2,263.6 мянга, өвсний авлага 4,349.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 137,975.0 мянган төгрөг болж 13,169.0 мянган төгрөгөөр өссөн нь өвс тэжээлийн үлдэгдэл 9,219.0 мянга, бичиг хэргийн материал 300.0 мянга, аж ахуйн материал 650.0 мянга, нөөцийн бараа 3,000.0 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Бараа материалын орлогод сумын ОНХС, Сум дундын ойн анги болон ОБЕГ-аас нийт 113,152.6 мянган төгрөгийн өвс тэжээл, нөөцийн бараанд 3,000.0 мянган төгрөгийн хөрсний шинжилгээний зураг төсвийг үнэ төлбөргүй шилжүүлсэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,597,317.6 мянган төгрөг болж 118,132.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 16,159.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 53,900.0 мянган төгрөгийн худаг, уул уурхайн хандиваар 36,000.0 мянган төгрөгийн барилга их засвар, 2,700.0 мянган төгрөгийн мотоцикл, 5,552.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 3,820.0 мянган төгрөгийн тавилга хэрэгслийг үнэ төлбөргүй шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,151,769.8 мянган төгрөг болж 156,781.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 156,781.6 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр зарлагыг 401,584.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 57,523.5 мянган төгрөгөөр бууруулж 344,060.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийн тодотголоор 77,217.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн гэрэл цахилгаан, хангамж бараа материалын зардал, эд хогшил авах зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 421,277.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 420,277.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 420,277.9 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 10.0 мянган төгрөгийн орлого орж, урсгал үйл ажиллагаанд 406,995.7 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсвийн санхүүжилтээс 13,292.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 406,995.7 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 3,902.0 мянга, НДШ-ийн зардлаас 5,009.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1,698.5 мянга, хангамж бараа материалын зардал 1,587.6 мянга, эд хогшил, урсгал засварын зардал 150.1 мянга, дотоод албан томилолт 551.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 818.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 413.3 мянга, урсгал шилжүүлгээс 150.8 мянган төгрөг тус тус зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 14,686.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 12,422.5 мянган төгрөг зарцуулж 2,263.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

№	Зориулалт	Орлого	Зарцуулсан	Төвлөрүүлсэн
1	Хучирхийлэлгүй сум төсөл	6,300.0	4036.359	2,263.6
2	Хамтарсан багийн зардал	300.0	300.0	-
3	Мал тооллогын зардал	940.5	940.5	-
4	аймгийн Засаг даргын захирамж А/44 өвөлжилт хүндэрсэн сумдад тусламж	1,000.0	1,000.0	-
5	Аймгийн Засаг даргын Захирамж А/83 Малчдад өвс хүргэх	2,945.6	2,945.6	-
6	аймгийн ЗД-ын нөөц хөрөнгө иргэнд тусламж	1,500.0	1,500.0	-
7	Аймгийн Засаг даргын Захирамж А/573 Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьд сэргийлэх зардалд	1,700.0	1,700.0	-
	Нийт дүн	14,686.1	12,422.5	2,263.6

Эх сурвалж: Шинэжинст сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 74 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 86 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Б.Азбаяр аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 698,110.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 57,586.8 мянган төгрөгөөр буюу 9.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, нормативд зардал, урсгал засвар, бараа үйлчилгээний зардал, урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос өсөж, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 458,091.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 56,908.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 мөнгөн гүйлгээний 35,930.4 мянган төгрөгийг мэдээлээгүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	34	2	
5	Тухай бүр	8	96	86	10	
	Нийт	27	151	134	15	2

Энэ нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд нийт 421,277.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 406,995.7 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 13,292.2 мянган төгрөг буюу төсвийн 3.1 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 18,081.1 мянган төгрөгөөр батлагдаж тодотголоор 28.5 мянган төгрөгийг нэмэгдүүлэн баталж гүйцэтгэлээр 16,411.1 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэж байна.

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд дотуур байрны хоол хүнс, үдийн цайны хүнсний материал нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба аудитаар нийт 301900,6 мянган төгрөгийн 4 төрлийн алдаа, зөрчил илэрсэнд 301900,6 мянган төгрөгийн 2 залруулга хийж шилэн дансны мэдээлэл болон өвсний тооцоотой холбоотой 2 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг Шинэжинст сумын ЗДТГ-ын 2021.06.14-ний тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 100,259.3 мянган төгрөгийн 5 зөрчил илэрч 1,420.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 98,839.3 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй 2 зөвлөмжийг хүргүүлээ.

4.1 Төлбөрийн акт

1.ЗДТГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 14 ний А/31 тоот тушаалаар тэмцээнд оролцох баг тамирчдад нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,000.0 төгрөгөөр тоглолтын хувцас хийлгэж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, гэсэн заалтууд, санхүүгийн тайлангийн “ Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвөөс зориулалт бусаар зарцуулсан 1,000.0 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Цалингаас дундын суутгал 420.0 мянган төгрөгийг суутгалгүй төсвөөс илүү шилжүүлж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төсвөөс илүү шилжүүлсэн 420.0 мянган төгрөгийг цалингаас суутгаж төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4.2 Албан шаардлага

1. Сумын ЗДТГ-ын 2021.12.14-ний өдрийн А/32 дугаар тушаалаар жилийн эцсийн тооллого явуулах ажлын хэсэг томилогдож эд хөрөнгийг тоолсон ба тооллогын комисс нь тооллого хийсэн тухай тэмдэглэл үйлдэж өмч хамгаалах зөвлөлд хүргүүлээгүй, нягтлан бодогч тооцоог бодож тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалт санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгийн тооллогыг хийж үр дүнг баталгаажуулж ирүүлэх албан шаардлага өгөв.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Сумын хот тохижилт үйлчилгээний алба ОНӨААН-ийн дансанд хог хаягдлын зардалд сар бүр 500.0 мянган төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу нийт 6,000.0 мянган төгрөгийг тус байгууллагатай гэрээ байгуулаагүй ямар үйлчилгээ авсан нь тодорхойгүй байхад шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Сумын хот тохижилт үйлчилгээний албатай ажил үйлчилгээний гэрээ байгуулан төлбөрийг нэхэмжлэлийн дагуу шилжүүлж байх

2. Тус байгууллага нь 2021 онд нийт 458,091.3 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 56,908.9 мянган төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 3 мөнгөн гүйлгээний 35,930.4 мянган төгрөгийг мэдээлээгүй байна

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын бүрэн, үнэн зөв мэдээлж байх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		1/мянган төгрөгөөр/							
				Үүнээс				Зөвлөмж			
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
1	Шинэжинст сумын ЗДТГ	5	100,259.3			2	1,420.0	1	0	2	98,839.3

оОо